



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ар ус ундарга ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/223/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn Архангай аймаг 2022 он	Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас:7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК Утас: 99099119 Цахим хаяг: gerelthuhaudit@gmail.com
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан.....	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	7
3. Аудитын тайлан	7
3.1 Ерөнхий зүйл.....	7
3.2 Дотоод хяналт.....	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	8
3.4 Материаллаг байдал	8
4. Санхүүгийн тайлангийн тодруулга	8
4.1 Байгууллагын үйл ажиллагаа.....	8
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	8
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	9
4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	11
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	11
5.1 Шилэн дансны мэдээлэл.....	11
5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	12
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал	13
8. Аудитын илрүүлэлт	13
8.1 Залруулсан алдаа	13
8.2 Албан шаардлага	14
8.3 Зөвлөмж	14
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	0

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.Аудитын санал дүгнэлт



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс: 976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

Г "АР УС УНДАРГА" ОНӨААТҮГ-ЫН Г
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Ч.ТҮВШИНТӨГС ТАНАА

2022.08.30 № 159
танай _____-ны № _____-т
Г Аудитын санал дүгнэлт Г

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Ар ус ундарга" ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэлд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол "Ар ус ундарга" ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тайлант онд тус компани нь 2.1 сая төгрөгийн бараа материалыг орлого авалгүй шууд зардалд бүртгэж тайлагнасан, орон нутгийн өмчийн газраас зөвшөөрөл авалгүйгээр 80.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч бэлтгэсэн, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй, санхүүгийн тайланд өр төлбөрийн үлдэгдлээр тайлагнасан 111.3 сая төгрөгийн өрийг холбогдох байгууллагуудтай тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.1, 14.4.3, 20 дугаар зүйлийн 20.2.6, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 46 дугаар зүйлийн 46.1.4-1.5, 48 дугаар зүйлийн 48.5, Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан "Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх заавар", Компанийн дүрмийн 6.6.12 дахь заалтуудтай нийцэхгүй, эрх ба үүрэг, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

			/төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	484,757,459.60	426,832,259.50
1.1.02	Дансны авлага	26,499,854.98	101,878,541.00
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	267,780.44	-
1.1.04	Бусад авлага	6,775,970.47	4,680,000.00
1.1.06	Бараа материал	120,674,091.17	194,317,513.60
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		4,589,138.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	638,975,156.66	732,297,452.10
1.2.01	Үндсэн хөрөнгө	8,920,754,419.48	1,192,626,531.00
1.2.02	Биет бус хөрөнгө	3,395,610,000.00	3,395,610,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	12,316,364,419.48	4,588,236,531.00
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	12,955,339,576.14	5,320,533,983.00
2.1.1.02	Дансны өглөг	299,093,630.48	111,281,388.97
2.1.1.03	Татварын өр	3,347,627.68	3,981,446.34
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	1,247,999.72	4,511,813.59
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	810,000.00	2,140,887.60
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	304,499,257.82	121,915,536.50
2.1.2.01	Урт хугацаат зээл	11,170,956,531.26	2,229,007,293.00
2.1.2.02	Урт хугацаат зээлийн бусад хэсэг		299,093,630.48
2.1.2.06	Урт хугацаат өр төлбөрийн дүн	11,470,050,161.74	2,528,100,924.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	11,475,455,789.08	2,650,016,460.00
2.3.01	Өмч: - төрийн	351,271,342.50	351,271,342.50
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	206,573,729.30	206,573,729.30
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	3,395,610,000.00	3,395,610,000.00
2.3.09	Хуримтлагдсан ашиг	(2,473,571,284.76)	(1,282,937,549.00)
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	(314,923,389.06)	(1,211,084,313.00)
2.3.11	Эздийн өмчийн дүн	1,479,883,787.06	2,670,517,523.00
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	12,955,339,576.14	5,320,533,983.00

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант хугацааны дүн
1	Борлуулалтын орлого (цэвэр)	910,438,437.17	1,325,184,994.00
2	Борлуулалтын өртөг	986,526,499.03	1,236,209,221.00
3	Нийт ашиг(алдагдал)	(76,088,061.86)	88,975,772.65
4	Түрээсийн орлого	11,797,089.00	989,200.00
5	Хүүний орлого	48,384,786.00	76,969,282.86
8	Бусад орлого	26,290,302.82	1,200,000.00
8.1	Орлогын дүн	86,472,178.90	79,158,482.86
10	Ерөнхий ба удирдлагын зардал	68,353,538.30	183,015,465.60
12.1	Зардлын дүн	68,353,538.30	183,015,465.60
17	Бусад ашиг (алдагдал)	(28,305,966.80)	(49,275,097.35)
17.1	Олз, гарзын дүн	(7,987,957,679.47)	(49,275,097.35)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	(8,074,233,068.61)	(64,156,307.44)
19	Орлогын татварын зардал	-	7,696,928.14
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(8,074,233,069.00)	(71,853,235.58)
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(8,074,233,069.00)	(71,853,235.58)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмч	ХөрДахҮнНэм	ЭздӨмчБусХэсэг	ХурАшиг	Нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл	351,271,342.50	206,573,729.30	3,395,610,000.00	(314,923,389.06)	1,479,883,787.06
2	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	7,178,072,144.00	7,178,072,144.00
3	Залруулсан үлдэгдэл	351,271,342.50	3,285,274,660.00	3,395,610,000.00	6,863,148,755.00	13,895,304,758.00
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(8,074,233,069.00)	(8,074,233,069.00)
7	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	(3,078,700,931.00)	-	-	(3,078,700,931.00)
9	2020 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл	351,271,342.50	206,573,729.30	3,395,610,000.00	(1,211,084,313.00)	2,742,370,758.00
10	НББ-н бодлогын өөрчлөлтийн	-	-	-	-	-

	нөлөө, алдааны залруулга					
11	Залруулсан үлдэгдэл	351,271,342.50	206,573,729.30	3,395,610,000.00	(1,211,084,313.00)	2,742,370,758.00
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(71,853,235.58)	(71,853,235.58)
13	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
17	2021 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл	351,271,342.50	206,573,729.30	3,395,610,000.00	(1,282,937,549.00)	2,670,517,523.00

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

			/төгрөгөөр/
1	Үзүүлэлт	Үзүүлэлт	Үзүүлэлт
1	Тайлант үеийн цэвэр ашиг	0	0
1.1	Тайлант үеийн цэвэр ашиг (+)	1,093,227,948.42	1,821,300,772.20
1.1.1	Алдаагчид үйлдвэрлэл, үйлчилгээний үйлдвэрлэл	1,092,693,788.42	1,776,897,736.36
1.1.6	Алдаагчид үйлдвэрлэл, үйлчилгээний үйлдвэрлэл	534,160.00	44,403,035.84
1.2	Тайлант үеийн цэвэр ашиг (-)	1,083,485,806.69	1,918,301,894.21
1.2.1	Алдаагчид үйлдвэрлэл, үйлчилгээний үйлдвэрлэл	436,737,860.00	510,574,959.50
1.2.2	Алдаагчид үйлдвэрлэл, үйлчилгээний үйлдвэрлэл	124,412,988.49	124,674,625.19
1.2.3	Алдаагчид үйлдвэрлэл, үйлчилгээний үйлдвэрлэл	107,455,055.00	13,728,879.85
1.2.4	Алдаагчид үйлдвэрлэл, үйлчилгээний үйлдвэрлэл	213,455,618.78	276,695,901.25
1.2.5	Өрхөөлөгчид үйлдвэрлэл, үйлчилгээний үйлдвэрлэл	25,871,020.00	9,098,170.00
1.2.7	Өрхөөлөгчид үйлдвэрлэл, үйлчилгээний үйлдвэрлэл	129,692,448.78	174,992,671.99
1.2.9	Алдаагчид үйлдвэрлэл, үйлчилгээний үйлдвэрлэл	77,691,815.64	808,536,686.43
1.3	Тайлант үеийн цэвэр ашиг огуурттай үйлдвэрлэл, үйлчилгээний үйлдвэрлэл	(22,087,858.27)	(97,001,122.01)
2.2	Тайлант үеийн цэвэр ашиг (-)		-
2.2.1	Тайлант үеийн цэвэр ашиг огуурттай үйлдвэрлэл, үйлчилгээний үйлдвэрлэл		-
2.3	Өрхөөлөгчид үйлдвэрлэл, үйлчилгээний үйлдвэрлэл	0	39,075,921.92
4	Алдаагчид үйлдвэрлэл, үйлчилгээний үйлдвэрлэл	(22,087,858.27)	(57,925,200.09)
5	Тайлант үеийн цэвэр ашиг огуурттай үйлдвэрлэл, үйлчилгээний үйлдвэрлэл	506,845,317.87	484,757,459.60
6	Тайлант үеийн цэвэр ашиг огуурттай үйлдвэрлэл, үйлчилгээний үйлдвэрлэл	484,757,459.60	426,832,259.51

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Нийт орлого	мян. Төг	910,438.44	1,598,152.8	1,404,760.9	(193,391.9)	87.9
2	Нийт зарлага	мян. Төг	986,526.5	1,596,063.7	1,476,614.1	(119,449.6)	92.5
3	Нийт ашиг	мян. Төг	(76,088.06)	2,089.1	(71,853.2)	(73,942.3)	-

3. Аудитын тайлан**3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Ар ус Ундарга ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгадагч байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, шилэн дансны хууль, “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмж, албан шаардлага, төлбөрийн актыг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс с 2022 оны 3 дугаар сарын 15-ны хооронд Гэрэлт хөхийн тэнцвэр Аудит ХХК-ийн аудитор Л.Амарзаяа гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Ж.Ням-Осор, захирал Д.Баатарсайхан нар хэрэгжүүллээ.

“Ар ус ундарга” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланг Гэрэлт Хөхийн тэнцвэр аудит ХХК-д 2022 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн 201 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Тус байгууллага нь Монгол Улсын Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7.2, 8.2.1 дэх заалт, Засгийн газрын 2011 оны 11 дүгээр сарын 9-ны өдрийн 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт зохион байгуулах нийтлэг журмын дагуу дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд компанийн удирдлагаас дотоод хяналт хэрэгжүүлээгүй учир төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзсэн болно.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгууллага нь дотоод аудитын орон тоо, хэлтэс, тасаггүй учир дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авах дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Ар ус ундарга ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшин 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогын 1,325.2 сая төгрөгөөс 1 хувиар буюу 13.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 9.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Ар ус ундарга ОНӨААТҮГ-ын зорилго нь аж ахуйн нэгж байгууллага, иргэдийг стандартын шаардлага хангасан цэвэр усаар хангаж, бохир усыг байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр татан зайлуулж, хөнгөн шуурхай үйлчлэхэд оршино.

Компанийн дүрэмд тус байгууллага дараах үйл ажиллагааг эрхлэн явуулна гэж заажээ. Үүнд:

- Цэвэр усны хангамж
- Бохир ус ариутгах , татуурга зайлуулах
- Халуун усны үйлчилгээ
- Барилга,сантехникийн засвар
- Дэлгүүр
- Худалдаа
- Засвар үйлчилгээ гэж тодорхойлжээ.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Архангай аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2020 оны 10 дугаар сарын 28-ний өдрийн 51 дүгээр тогтоолоор “Ар Ус Ундарга” ОНӨААТҮГ нь 100 хувь орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар бөгөөд компанийн өмчлөгч нь Эрдэнэбулган сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байна. Энэ хүрээнд ИТХ-н тэргүүлэгчид нь 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө

оруулалтын төлөвлөгөөг баталж, 2021 оны 3 дугаар сарын 05-ны өдөр хүртэл үйл ажиллагааг удирдан зохион байгуулж байсан. Балансын дараах үйл явдал буюу 2022 оны 2 дугаар сарын 11-нд аймгийн Засаг даргын Б/10 тоот захирамжаар компанийн удирдлага солигдсон байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно” гэж заасан байна.

Энэ хүрээнд Архангай аймгийн Эрдэнэбулган сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 03 дугаар тогтоолоор “Ар ус ундарга” ОНӨААТҮГ-н 2021 оны үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг баталсан бөгөөд уг тогтоолоор өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж ажиллах, төсөвт тусгагдсан эрхийн хүрээнд байгууллагын үйл ажиллагааг удирдан зохион байгуулахыг үүрэг болгосон.

2021 оны 12 дугаар сард Архангай аймгийн Эрдэнэбулган сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид хуралдан компанийн үйл ажиллагааны 2021 оны тайлантай танилцан үйл ажиллагааны үр дүнг дүгнэж, цаашид авах арга хэмжээний талаарх чиглэлийг хүргүүлсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт орсон байна.Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2012 онд дотоодын хэрэгцээндээ зориулан өөрсдөө боловсруулж мөрдөж байсныг 2021 онд “World finance audit” ХХК -аар шинэчлэн боловсруулж мөрдөж эхэлсэн байна.

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	484,757.5	426,832.3	(57,925.2)
Авлага	27,192.7	106,558.5	79,365.9
Урьдчилгаа		4,589.1	(4,589.1)
Бараа материал	120,674.1	194,317.5	73,643.4
Үндсэн хөрөнгө	8,920,754.4	1,192,626.5	(7,728,127.9)
Биет бус хөрөнгө	3,395,610.0	3,395,610.0	-
Нийт хөрөнгийн дүн	12,955,339.5	5,320,534.0	(7,634,805.5)
Өр төлбөрийн дүн	11,475,455.8	2,650,016.4	(8,825,439.4)
Богино хугацаат өглөг	304,499.3	121,915.5	(182,583.8)
Урт хугацаат өглөг	11,170,956.5	2,229,007.3	(8,941,949.2)
Урт хугацаат өглөг бусад		299,093.6	(299,093.6)
Эздийн өмч	1,479,883.7	2,670,517.5	1,190,633.8

Арилжааны Банкин дахь харилцах данс оны эцэст 426.8 сая төгрөгийн мөнгөн хөрөнгө үлдэгдэлтэйгээс хугацаатай хадгаламжийн үлдэгдэл 300.0 сая төгрөг байна. Тус хадгаламжийн дүн оны эхэнд 305.0 сая төгрөгтэйгөөс тайлант онд 5.0 сая төгрөгийг

харилцах дансанд шилжүүлсэн. Энэ хугацаатай хадгаламж нь нийт мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 70 хувийг эзэлж байна.

Тайлант оны эцэст авлагын үлдэгдэл 106.5 сая төгрөг болж өмнөх оноос 79.3 сая төгрөгөөр нэмэгдсэнд иргэн, аж ахуй нэгж байгууллагын төлбөрийг төрөөс хариуцаж төлөх санхүүжилт компанид бүрэн орж ирээгүйтэй холбоотой байна. Авлагын үлдэгдэлд хэвийн 101.9 сая төгрөг, хугацаа хэтэрсэн 4.6 сая төгрөгийн авлага байх бөгөөд найдваргүй авлага байхгүй.

Тайлант оны эцэст 4.5 сая төгрөгийн урьдчилгаа авлага бүртгэгдсэн нь ажилчдад олгосон цалингийн урьдчилгаа суутган тооцож барагдуулаагүйгээс үлдэгдэлтэй гарсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 194.3 сая төгрөг болж 73.6 сая төгрөгөөр өссөн нь шугам сүлжээний аюулгүй ажиллагааг найдвартай хангах үүднээс засварын сэлбэг, материал бэлтгэсэн байдлаас шалтгаалжээ. Бараа материал худалдан авч бэлтгэхдээ холбогдох хууль, журмыг мөрдөөгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4 “хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 “Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дор дурдсан тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулна”, 46 дугаар зүйлийн 46.1.4 “худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, зохион байгуулах”, 46.1.5 “энэ хуулийн 7.6-д зааснаас бусад бараа, ажил, үйлчилгээг санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэр батлагдсаны дараа худалдан авах ажиллагааг эхлүүлэх”, 48 дугаар зүйлийн 48.5 “Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тухайн жилийн төсөв батлагдсанаас хойш нэг сарын дотор хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 1,192.6 сая төгрөг болж буурсан нь Архангай аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2021 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор “Ар ус ундарга” ХХК-н өмчид бүртгэлтэй 45 нэр төрлийн 8,109.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг орон нутгийн өмчийн газарт шилжүүлсэнтэй холбоотой байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 121.9 сая төгрөг болж, 182.6 сая төгрөгөөр буурсан нь Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банкны хооронд 2002 оны 9 дүгээр сарын 05-ны өдөр байгуулсан гэрээний хүрээнд хийгдсэн 299.0 сая төгрөгийн ажлын нэг хэсгийг бүртгэсэн бөгөөд үүнийг өмнөх аудитаар дансны өглөгт бүртгэснийг залруулж урт хугацаат өглөгийн бусад хэсэг гэсэн дансанд бүртгэлээ.

Дансны өглөг дансанд бүртгэгдсэн 111.3 сая төгрөг нь усны үнийн хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдсан 18 сумдад хуваарилах өр төлбөрийн үлдэгдэл гэсэн тайлбар өгч байгаа боловч өр төлбөрийн үлдэгдлийг сум тус бүрээр тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.1 “аж ахуйн бүх ажил гүйлгээ”, 14.4.3 “бүх өр төлбөр”, 20 дугаар зүйлийн 20.2.6 “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай нийцэхгүй байна.

Урт хугацаат өр төлбөрийн дүн 8,941.9 тэрбум төгрөгөөр буурсан. Энэ нь Архангай аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2021 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор “Ар ус ундарга” ХХК-н өмчид бүртгэлтэй 45 нэр төрлийн 8,109.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, бусад магадлашгүй ажил, сургалт, нормчлолын сангийн зардал бүхий нийт 8,941.9 сая төгрөгийн хөрөнгийг орон нутгийн өмчийн газарт шилжүүлсэнтэй холбоотойгоор урт хугацаат зээл дансыг бууруулан бүртгэсэн байна.

4.4. ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШНИЙ ГҮЙЦЭТГЭЛ

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Архангай аймгийн Эрдэнэбулган сумын ИТХ-аас байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, батлуулан, биелэлтийг хянан ажиллаж байна.

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын ИТХ-н Тэргүүлэгчдийн 2021 оны 01 дүгээр сарын 18-ны 03 дугаар тогтоолоор “Ар ус ундарга” ХХК-н 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталжээ. Тайлант оны нийт орлогыг 1,598.1 сая, нийт зардлыг 1,596.0 сая, ашгийг 2.1 сая төгрөгөөр тус тус тогтоожээ.

Гүйцэтгэлээр 1,404.8 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, 1,404.0 сая төгрөгийн зардал гарган 0.4 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл төлөвлөснөөс 193.3 сая төгрөг буюу 12 хувиар тасарсан байгаа нь Компанийн 2021 оны эдийн засгийн үзүүлэлтээр ковид цар тахлын үеэр сургууль цэцэрлэгүүдийн үйл ажиллагаа явагдахгүй усны төлбөр багассан байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу өөрийн эх үүсвэрээс 80.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг /үндсэн хөрөнгө/ санхүүжүүлсэн байна. Хөрөнгө оруулалтын төсөв батлуулсан хэдий ч орон нутгийн өмчийн газраас хөрөнгө бэлтгэх зөвшөөрөл аваагүй, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө баталж, хуулийн дагуу тендер шалгаруулалт зохион байгуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 “Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дор дурдсан тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулна”, 46 дугаар зүйлийн 46.1.4 “худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, зохион байгуулах”, 46.1.5 “энэ хуулийн 7.6-д зааснаас бусад бараа, ажил, үйлчилгээг санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэр батлагдсаны дараа худалдан авах ажиллагааг эхлүүлэх”, 48 дугаар зүйлийн 48.5 “Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тухайн жилийн төсөв батлагдсанаас хойш нэг сарын дотор хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ”, компанийн дүрмийн 6.6.12-т “Компанийн шинээр худалдан авах болон акталж устгах, худалдах, шилжүүлэх үндсэн хөрөнгийн асуудлыг өмчийн асуудал хариуцсан байгууллагад гаргаж шийдвэрлүүлэх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Тайлант онд цэвэр ашиг 0.4 сая төгрөг болж, төлөвлөснөөс 1.7 сая төгрөгөөр дутуу байгаа нь ковид цар тахлын үеийн халдвар хамгааллын зардал өссөн нь голлон нөлөөлж байна.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 61 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь тайлант онд нийт 146 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 95 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 51 мэдээллийг хугацаа хоцроосон байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн зөрчилд өмнөх онд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан тул хариуцлага тооцуулах албан шаардлагыг хүргүүлэв.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд дараах алдаа зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. Байгууллагын 30 жилийн ойд зориулж бэлэг, ном, эд зүйл худалдан авахад 19.8 сая, шинэ жилийн баяр, ёслол хүлээн авалтын зардалд 8.6 сая, ажилчдад ажлын үр дүнг үнэлэн шагнал, урамшуулал олгоход 10.7 сая, өмгөөлөгчийн хөлсөнд 7.5 сая, нийт 46.6 сая төгрөгийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.3-д “Төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх”, 1.6-д “Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож Засгийн газрын 2021 оны 43 дугаар, 388 дугаар тогтоолуудын хэрэгжилтийг хангаж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

2. Худалдан авсан бараа, ажил үйлчилгээний төсөвт өртөг нь Засгийн газраас тогтоосон худалдан авах ажиллагааны харьцуулалт, шууд худалдан авч болох төсөвт өртгөөс хэтэрсэн байхад төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагааг зохион байгуулсан, зарим тохиолдолд шууд гэрээ байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5-д “Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож хариуцлага тооцох арга хэмжээ авах албан шаардлага хүргүүлэв.

3. Эрх бүхий байгууллага, удирдлагын шийдвэргүйгээр компанийн захирал Б.Булганчимэгийн сургалтын төлбөрт 2.7 сая төгрөгийг төлсөн. Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.3-д “...төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, ... цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх ...” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2, МУЕА-ын 2020 оны А/95 тушаалаар баталсан журмын 4.2.3.8 дахь заалтыг үндэслэн төлбөрийн акт тогтоох

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгасан хүрээнд хамаарах асуудал нь холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 86.5 сая төгрөгийн зөрчилд 6 албан шаардлага хүргүүлж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгснөөс шилэн данстай холбоотой албан шаардлага хэрэгжээгүй байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	6	86.5	6	86.5	0	0	100
Зөвлөмж	3	0	2	0	1	0	66.7
Нийт дүн	9	86.5	8	86.5	1	0	66.7

6 Албан шаардлага бүрэн биелж, 3 зөвлөмжийн 2 зөвлөмж хэрэгжиж, шилэн данстай холбоотой хэрэгжээгүй 1 зөвлөмж хэрэгжээгүй байна.

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Үндсэн хөрөнгө, борлуулсан бүтээгдэхүүний өртгийн дансыг шалгах

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар санхүүгийн тайлантай холбоотой 291.6 сая, нийцлийн аудитын 49.3 сая, нийт 340.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрлээ. Санхүүгийн тайлантай холбоотой алдаа зөрчлөөс 91.1 сая төгрөгийн алдааг залруулж, 198.4 сая төгрөгийн 3 зөрчлийг арилгах албан шаардлага, 2.1 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өглөө. Санхүүгийн аудитаар шалгасан нийцлийн аудиттай холбоотой илэрсэн 49.3 сая төгрөгийн зөрчлөөс 2.7 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлэх 1 төлбөрийн акт тогтоож, 46.6 сая төгрөгийн 6 зөрчилд албан шаардлага хүргүүллээ.

Залруулагдаагүй 200.5 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 13.3 сая төгрөгийн түвшнээс их байх тул хязгаарлалттай санал дүгнэлт өглөө.

8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 91.1 сая төгрөгийн 3 алдааг залрууллаа. Үүнд:

- Борлуулсан бүтээгдэхүүний өртөг дансыг 70.3 сая төгрөгөөр бууруулж алдаатай бүртгэл хийсэн
- Борлуулалт, удирдлагын зардлын ангилалд бүртгэх ёстой 16.2 сая төгрөгийн зардлыг борлуулсан бүтээгдэхүүний өртөг дансанд бүртгэж алдаатай бүртгэсэн
- Бусад зардлын ангилалд бүртгэсэн 4.6 сая төгрөгийн ажил гүйлгээг дансны буруу бичилт хийж ногдол ашгийн татварын урьдчилгаа дансанд бүртгэсэн тус тус алдаа зөрчил гаргасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14-р зүйл "Нягтлан бодох бүртгэл хөтлөх" Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралт "Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх заавар"-ыг мөрдөж ажиллаагүй, үнэн зөв батламж мэдэгдлийг хангаж ажиллаагүй байна.

8.2 Албан шаардлага

- Тус байгууллага нь 80.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авахдаа орон нутгийн өмчийн газраас шийдвэр гаргуулаагүй байгаа нь ТБОНӨХБАҮХАТ хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14-р зүйл "Нягтлан бодох бүртгэл хөтлөх", Тус компанийн батлагдсан дүрмийн 6.6.12-т "Компанийн шинээр худалдан авах болон акталж устгах, худалдах, шилжүүлэх үндсэн хөрөнгийн асуудлыг өмчийн асуудал хариуцсан байгууллагад гаргаж шийдвэрлүүлэх" гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шинээр үндсэн хөрөнгө худалдан авахдаа өмчийн асуудал хариуцсан байгууллагын зөвшөөрөл аваагүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

- Монгол улсын ЗГ-ын 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн дугаар 211 тоот тогтоолоор "Коронавирус халдвар /ковид-19/-ын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай" шийдвэрийн хүрээнд Хот суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөлөөс тайлант онд төрөөс хариуцах усны мөнгө болох нийт 974.5 сая төгрөгийн санхүүжилт авахаас гүйцэтгэлээр 779.1 сая төгрөгийн санхүүжилт авч 195.4 сая төгрөгийн авлагатай байгааг тооцоо нийлж баталгаажуулсан, харин энэ санхүүжилтээс 18 сумуудад хуваарилах 116.4 сая төгрөгийг өглөгөөр бүртгэн тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр, 20 дугаар зүйлийн 20.2.6-д заасныг хэрэгжүүлж төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлэн баталгаажуулж цаашид давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

- Архангай аймгийн Эрдэнэбулган сумын нэгдүгээр сургуульд 1.5 сая төгрөгийн хандив өгсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 25.10-д "Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно" гэж заасныг зөрчжээ.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

8.3 Зөвлөмж

Бараа материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Худалдан авсан бараа 2.1 сая төгрөгийн материалыг орлого аваагүй шууд зардалд бүртгэж тайлагнасан тус тус алдаа зөрчил гаргасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14-р зүйл "Нягтлан бодох бүртгэл хөтлөх" Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх заавар"-ыг мөрдөж ажиллаагүй, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид бараа материалыг худалдан авсан тухай бүр холбогдох дансанд орлогоор бүртгэж хэвших.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мян. төгрөгөөр/														
№	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа, зөрчлийн товч утга	Аудитын байгууллагын тогтоосон акт, албан шаардлага, өгсөн зөвлөмж, залруулгын товч утга	Нийт алдаа зөрчил		Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар														
1	Ар ус ундарга ОНӨААТҮГ	АРА-2022/223/НА-СТА-ОНА	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг дансыг бууруулж алдаатай бүртгэл хийсэн	Зардлын дансыг зөв бүртгэх зөвлөмж өгч залруулга хийлгэсэн	1	70,309.30	1	70,309.3						
2	Ар ус ундарга ОНӨААТҮГ	АРА-2022/223/НА-СТА-ОНА	Борлуулалт, удирдлагын зардлын ангилалд бүртгэх ёстой зардлыг борлуулсан бүтээгдэхүүний өртөг дансанд бүртгэж алдаатай толилуулсан	Зардлын дансыг зөв бүртгэх зөвлөмж өгч залруулга хийлгэсэн	1	16,240.50	1	16,240.5						
3	Ар ус ундарга ОНӨААТҮГ	АРА-2022/223/НА-СТА-ОНА	Бусад зардлын ангилалд бүртгэсэн ажил гүйлгээг дансны буруу бичилт хийж ногдол ашгийн татварын урьдчилгаа дансанд бүртгэсэн байна.	Зардлын дансыг зөв бүртгэх зөвлөмж өгч залруулга хийлгэсэн	1	4,589.10	1	4,589.1						
4	Ар ус ундарга ОНӨААТҮГ	АРА-2022/223/НА-СТА-ОНА	Худалдан авсан бараа материалыг орлого аваагүй шууд зардалд бүртгэж тайлагнасан	Бараа материалыг орлого авч зөв бүртгэх зөвлөмж өгсөн	1	2,126.30							1	2,126.3
5	Ар ус ундарга ОНӨААТҮГ	АРА-2022/223/НА-СТА-ОНА	Архангай аймгийн эрдэнэбулган сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуульд хандив өгсөн	Төсвийн тухай хуулийн 25.10 заалтыг мөрдөж ажиллах; албан шаардлага хүргүүлэх	1	1,450.00					1	1,450.0		
6	Ар ус ундарга ОНӨААТҮГ	АРА-2022/223/НА-СТА-ОНА	Сумдад олгох усны хөнгөлөлтийн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13,14-р заалтыг мөрдөж ажиллах албан	1	116,441.4					1	116,441.4		

/мян. төгрөгөөр/

Ар ус ундарга ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

				шаардлага хүргүүлэх										
7	Ар ус ундарга ОНӨААТҮГ	АРА- 2022/223/НА- СТА-ОНА	Үндсэн хөрөнгө худалдан авахдаа орон нутгийн өмчийн газраас шийдвэр гаргуулаагүй	Үндсэн хөрөнгө худалдан авах болон актлахдаа өмчийн газрын шийдвэр гаргуулаагүй албан шаардлага хүргүүлэх	1	80,432.40					1	80,432.40		
ДҮН					6	291,589.0	3	91,138.9	1	1,450.0	3	198,323.8	1	2,126.3
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудал														
1	Ар ус ундарга ОНӨААТҮГ	АРА- 2022/223/НА- СТА-ОНА	Байгууллагын 30 жилийн ойд зориулж бэлэг, ном, эд зүйл, бусад төрлийн зардлууд гаргасан	Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах; албан шаардлага хүргүүлэх	1	19,794.50					1	19,794.50		
2	Ар ус ундарга ОНӨААТҮГ	АРА- 2022/223/НА- СТА-ОНА	Эрх бүхий байгууллага, удирдлагын шийдвэргүйгээр компанийн захирал Б.Булганчимэгийн сургалтын төлбөр төлсөн	Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах; акт тогтоох	1	2,730.00			1	2,730.0				
3	Ар ус ундарга ОНӨААТҮГ	АРА- 2022/223/НА- СТА-ОНА	Шинэ жилийн баяр, ёслол хүлээн авалтын зардал гаргасан	Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах; албан шаардлага хүргүүлэх	1	8,585.30					1	8,585.30		
4	Ар ус ундарга ОНӨААТҮГ	АРА- 2022/223/НА- СТА-ОНА	Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хууль, эрх зүйн асуудлыг эрх бүхий дээд байгууллагаас шийдвэрлэх шаардлагатай байтал зориулалт бусаар өмгөөлөгч хөлсөлж үрэлгэн зардал гаргасан	Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах; албан шаардлага хүргүүлэх	1	7,508.00					1	7,508.0		

5	Ар ус ундарга ОНӨААТҮГ	АРА- 2022/223/НА- СТА-ОНА	Байгууллагын ажилчдад ажлын үр дүнг үнэлэн шагнал, урамшуулал олгосон	Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах; албан шаардлага хүргүүлэх	1	10,732.00					1	10,732.00		
6	Ар ус ундарга ОНӨААТҮГ	АРА- 2022/223/НА- СТА-ОНА	Тендер шалгаруулах босго үнийг давсан хэдий ч хэсэгчилсэн худалдан авалт хийсэн, мөн зарим харилцагч байгууллагуудад олгосон бараа ажил үйлчилгээний төлбөрт төлсөн мөнгөн дүн тендер зарлах босго үнийн дүн давсан боловч шууд гэрээ байгуулан ажилласан байна.	ТБОНӨХБАҮХАТ хуулийг мөрдөж ажиллах, хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэх	1						1			
7	Ар ус ундарга ОНӨААТҮГ	АРА- 2022/223/НА- СТА-ОНА	Тайлант хугацаанд байгууллагын шилэн дансны цахим хуудаст байршуулах 146 мэдээлэл оруулахаас 51 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна	Шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиллах, хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэх	1						1			
	ДҮН				8	49,349.8			1	2,730.0	6	46,619.8	-	-
	НИЙТ ДҮН				14	340,938.4	3	91,138.9	1	4,180.0	7	243,493.6	1	2,126.3